



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/291

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийн  
гэрчилгээнд өөрчлөлт тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол шинжлэх ухааны газрын дүгнэлтийг үндэслэн ерөнхий боловсролын сургуулиудын шинэ барилга ашиглалтад орсон, хэв шинж өөрчлөгдсөнтэй холбогдуулан сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2.Өөрчлөлт оруулах сургуулиудын мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу чанар, хүртээмжтэй зохион байгуулахыг тус сургуулийн захирлуудад, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

4.Өөрчлөлтийн талаарх мэдээллийг тус сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тэмдэглэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
дугаар сарын 21-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ СУРГУУЛИУД

№	Сум	Сургууль	Хуучин нөхцөл шаардлага	Шинэ нөхцөл шаардлага
1	Хэрлэн	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургууль, 68 бүлэг, багшлах боловсон хүчин (тоогоор 95), мэргэжлийн зэрэг, багшлах эрхтэй багшийн хувь 75,6 / 100, Хичээлийн болон дотуур байрны хүчин чадал 1120, 928/75	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 72 бүлэг, багшлах боловсон хүчин (тоогоор 101), мэргэжлийн зэрэг, багшлах эрхтэй багшийн хувь 70 / 101, Хичээлийн болон дотуур байрны хүчин чадал 1500/75
2	Хэрлэн	Тэмүүжин Ерөнхий боловсролын сургууль	Сургалтын байгууллагын нэр: Хэрлэн сумын ЕБ-ын Тэмүүжин цогцолбор сургуулийн хэв шинж: Гүнзгийрүүлсэн сургуулийн бүтэц: бага дунд ахлах анги бүлэг:50 чиглэл: 2-9 дүгээр ангийн математикийн сургалттай 16 бүлэг, багшлах боловсон хүчин:76, мэргэжлийн зэрэг багшлах эрхтэй багшийн хувтць: 94, 7/100, хичээлийн болон дотуур байрны хүчин чадал: 760/66	Сургалтын байгууллагын нэр: Хэрлэн сумын ЕБ-ын Тэмүүжин сургууль, сургуулийн хэв шинж: Гүнзгийрүүлсэн сургуулийн бүтэц: бага дунд ахлах анги бүлэг:64 чиглэл: 6-9 дүгээр ангийн математикийн сургалттай, багшлах боловсон хүчин:90, мэргэжлийн зэрэг багшлах эрхтэй багшийн хувь: 86/100%, хичээлийн болон дотуур байрны хүчин чадал: 1000/100
3	Бор-Өндөр	Бор-Өндөр Ерөнхий боловсролын сургууль	Бор-Өндөр цогцолбор сургууль 6-12-р ангийн 38 бүлэг,багшлах боловсон хүчин (тоогоор 63)мэргэжлийн зэрэг,багшлах эрхтэй 61% 64 Хичээлийн болон дотуур байрны хүчин чадал 770\100	Ерөнхий боловсролын Бор-Өндөр сургууль ,6-12-р ангийн 38 бүлэг,багшлах боловсон хүчин (тоогоор 63) мэргэжлийн зэрэг,багшлах эрхтэй багшийн хувь 61% 64 Хичээлийн байр болон дотуур байрны хүчин чадал Хичээлийн "А" байр-450, Хичээлийн "Б" байр-320, Дотуур байр-100